ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ШИВЭЭ ОВОО ХК-ИЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД:СНАГ-2025/60/НА-СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 260512 Цахим хаяг: Natsagdorjs@audit.gov.mn
Аудитор: М. Лхагвасүрэн
Утас: 261628 Цахим хаяг: lkhagvasurenm@audit.gov.mn
Юнистар аудит ХХК Захирал: М.Энхжаргал
Утас:11-328735 Цахим хаяг: info@unistaraudit.mn

Улаанбаатар хот
2025 он

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ 2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН 4
4. АУДИТЫН ТАЙЛАН 14
4.1 Ерөнхий зүйл 14
4.2 Материаллаг байдал 14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт 14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал 17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ 18
5.1 Төлбөрийн акт 18
5.2 Албан шаардлага 18
5.3 Зөвлөмж 19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ 20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ХК	Хувьцаат компани

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.12 № 07/1089
танай _____-ны № _____-т

ШИВЭЭ ОВОО ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Ц.ЭНХТҮВШИН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Шивээ Овоо ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Шивээ Овоо ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тус компанийн 1 тонн нүүрсний өртөг 48,046.79 төгрөг байхад Эрчим хүчний зохицуулах хорооны 2022 оны 589 дүгээр тогтоолоор баталсан үнэ 38,990.00 төгрөг байгаа нь компани алдагдалтай ажиллахад нөлөөлсөн байна. Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 695 дугаар тогтоолоор Шивээ овоо ХК-ийн 1 тонн нүүрсний үнийг 53,197.00 төгрөгөөр шинэчлэн тогтоосон байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант оны нийт орлогыг 115,709.6 сая төгрөгөөр, нийт зардлыг 130,669.6 сая төгрөгөөр, 14,960.0 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөсөн ба хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 37,658.2 сая төгрөг төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр

112,254.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 126,524.2 сая төгрөгийн зардал гарган, 14,269.7 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж, 27,346.6 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын арга хэмжээнд зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Шивээ Овоо ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолоор батлагдсан 2024 оны бизнес төлөвлөгөөгөөр 2,400.0 мянган тонн нүүрс олборлож, 2,380.0 мянган тонн нүүрс борлуулахаар анх төлөвлөсөн бол эрчим хүчний салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд 310.0 мянган тонн нүүрс нэмж олборлож борлуулахаар тодотгол хийсэн байна. Гүйцэтгэлээр нүүрс олборлолт өнгөрсөн оноос 154.2 мянган тонн, борлуулалтын хэмжээ 146.1 мянган тонноор тус тус нэмэгдсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.Н.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
1	**ХӨРӨНГӨ**		
1.1	**Эргэлтийн хөрөнгө**		
1.1.1	Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө	2,723,457,186.71	3,132,061,146.05
1.1.2	Дансны авлага	3,668,041,491.16	9,832,267,570.25
1.1.4	Бусад авлага	368,054,187.29	1,451,844,357.01
1.1.6	Бараа материал	25,112,107,392.26	23,802,832,630.65
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	398,196,862.12	411,737,021.28
1.1.11	**Эргэлтийн хөрөнгийн дүн**	**32,269,857,119.54**	**38,630,742,725.24**
1.2	**Эргэлтийн бус хөрөнгө**		
1.2.1	Үндсэн хөрөнгө	59,426,400,832.00	75,499,432,287.81
1.2.2	Биет бус хөрөнгө	155,223,197.03	149,109,157.36
1.2.7	Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө	627,169,395.40	627,169,395.40
1.2.10	**Эргэлтийн бус хөрөнгийн дүн**	**60,208,793,424.43**	**76,275,710,840.57**
1.3	**НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН**	**92,478,650,543.97**	**114,906,453,565.81**
2	**ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ**		
2.1	**Өр төлбөр**		
2.1.1	**Богино хугацаат өр төлбөр**		
2.1.1.1	Дансны өглөг	47,194,259,072.28	60,436,874,789.23
2.1.1.2	Цалингийн өглөг	1,400,043,367.00	1,657,497,279.00
2.1.1.3	Татварын өр	12,575,872,985.43	16,698,379,234.32
2.1.1.4	НДШ - ийн өглөг	7,300,612,233.14	5,564,919,653.14
2.1.1.5	Богино хугацаат зээл	-	20,810,000,000.00
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	13,041,910.10	13,041,910.10
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	9,262,188.26	262,530,408.80
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	8,908,080,517.37	10,476,531,121.26
2.1.1.13	**Богино хугацаат өр төлбөрийн дүн**	**77,401,172,273.58**	**115,919,774,395.85**
2.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	79,800,789,630.03	79,074,503,082.26
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	51,255,726.00	154,023,270.00
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	11,498,020,037.38	8,388,020,037.38
2.2.6	**Урт хугацаат ер төлбөрийн дүн**	**91,350,065,393.41**	**87,616,546,389.64**
2.2	**Өр төлбөрийн нийт дүн**	**168,751,237,666.99**	**203,536,320,785.49**
2.3	**Эздийн өмч**		
2.3.1	Өмч: - төрийн	1,207,710,000.00	1,207,710,000.00
2.3.2	- хувийн	134,190,000.00	134,190,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(77,614,487,123.02)	(89,971,767,219.68)
2.3.11	**Эздийн өмчийн дүн**	**(76,272,587,123.02)**	**(88,629,867,219.68)**
2.4	**ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН**	**92,478,650,543.97**	**114,906,453,565.81**

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	96,286,302,345.44	111,170,380,301.47
2	Борлуулалтын өртөг	102,134,404,117.07	118,129,203,462.0
3	**Нийт ашиг (алдагдал)**	**(5,848,101,771.63)**	**(6,958,823,160.58)**
5	Хүүний орлого	9,965,649.99	22,184,789.30
8	Бусад орлого	132,606,618.87	223,472,793.74
9	Борлуулалт, маркетингийн зардал	1,752,837,714.46	2,029,086,673.66
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,057,189,662.99	1,647,922,015.99
11	Санхүүгийн зардал	1,708,362,320.50	3,400,679,473.03
12	Бусад зардал	1,563,043,537.03	1,315,070,304.84
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	747,940,129.94	830,001,097.03
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	4,857,052.81	8,481,708.22
18	**Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)**	**(11,034,165,555.00**	**(14,267,441,239.81)**
19	Орлогын татварын зардал	1,353,058.24	2,218,478.93
20	**Татварын дараах ашиг (алдагдал)**	**(11,035,518,613.24)**	**(14,269,659,718.74)**
22	**Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)**	**(11,035,518,613.24)**	**(14,269,659,718.74)**
24	**Орлогын нийт дүн**	**(11,035,518,613.24)**	**(14,269,659,718.74)**
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	**1,341,900,000.00**	**(32,773,114,780.57)**	**(31,431,214,780.57)**
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	(33,805,853,729.21)	(33,805,853,729.21)
Залруулсан үлдэгдэл	1,341,900,000.00	(66,578,968,509.78)	(65,237,068,509.78)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	(11,035,518,613.24)	(11,035,518,613.24)
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	**1,341,900,000.00**	**(77,614,487,123.02)**	**(76,272,587,123.02)**
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	1,912,379,622.08	1,912,379,622.08
Залруулсан үлдэгдэл	1,341,900,000.00	(75,702,107,500.94)	(74,360,207,500.94)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	(14,269,659,718.74)	(14,269,659,718.74)
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	**1,341,900,000.00**	**(89,971,767,219.68)**	**(88,629,867,219.68)**

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
1	**Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ**		
1.1	**Мөнгөн орлогын дүн (+)**	**114,947,397,165.08**	**112,458,049,353.86**
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	100,932,189,764.21	112,156,751,515.80
1.1.6	Бусад мөнгөн орлого	14,015,207,400.87	301,297,838.06
1.2	**Мөнгөн зарлагын дүн (-)**	**96,236,660,797.69**	**107,396,648,631.66**
1.2.1	Ажиллагчдад төлсөн	14,746,927,602.00	15,517,943,292.30
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	2,861,000,000.00	6,950,000,000.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	28,703,637,734.12	25,379,895,198.19
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	37,328,292,900.07	45,287,524,098.39
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	249,456,589.61	679,753,077.77

1.2.7	Татварын байгууллагад төлсөн	3,228,974,270.62	2,502,903,193.28
1.2.9	Бусад мөнгөн зарлага	9,118,371,701.27	11,078,629,771.73
1.3	**Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн**	**18,710,736,367.39**	**5,061,400,722.20**
2	**Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ**		
2.2	**Мөнгөн зарлагын дүн (-)**	**10,741,117,127.43**	**21,872,068,391.13**
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	10,618,578,058.60	19,068,528,348.74
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	122,539,068.83	2,803,540,042.39
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(10,741,117,127.43)	(21,872,068,391.13)
3	**Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ**		
3.1	**Мөнгөн орлогын дүн (+)**	**-**	**24,000,000,000.00**
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	24,000,000,000.00
3.2	**Мөнгөн зарлагын дүн (-)**	**6,363,708,894.11**	**6,780,728,371.73**
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	3,017,364,274.00	3,332,183,616.00
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	3,180,000,000.00	3,110,000,000.00
3.2.6	Буцалтгүй тусламж	166,344,620.11	338,544,755.73
3.3	**Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн**	**(6,363,708,894.11)**	**17,219,271,628.27**
4	**Бүх цэвэр мөнгөн гүйлгээ**	**1,605,910,345.85**	**408,603,959.34**
5	Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,117,546,840.86	2,723,457,186.71
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,723,457,186.71	3,132,061,146.05

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2023 оны гүйцэтгэл	2024 оны			
				төлөвлөгөө	гүйцэтгэл	Зөрүү	Хувь
А	**Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт**						
1	Нүүрс олборлолт	м.тн	2,479.1	2,710.0	2,633.3	(76.7)	97.2
2	Нүүрс борлуулалт	м.тн	2,477.5	2,690.0	2,623.6	(66.4)	97.5
3	Хөрс хуулалт	м.м³	10,097.8	11,315.0	11,151.2	(163.8)	98.6
4	Дахин шидэлт	м.м³	3,258.4	3,340.0	3,558.6	218.6	106.5
5	Инженерийн ажил	м.м³	781.7	1,742.9	1,649.1	(93.8)	94.6
6	Нийт уулын цул	м.м³	16,186.7	19,488.8	18,535.2	(953.6)	95.1
Б	**Эдийн засгийн үндсэн үзүүлэлт**						
1	**Нийт орлого:**	**м.төг**	**97,181,671.8**	**115,709,566.3**	**112,254,520.7**	**(3,455,045.6)**	**97.0**
1.1	Үүнээс Цэвэр борлуулалт	м.төг	96,286,302.3	105,614,566.3	111,170,380.3	5,555,814.0	105.3
2	**Нийт зардал:**	**м.төг**	**108,215,837.4**	**130,669,606.0**	**126,524,180.4**	**(4,145,425.6)**	**96.8**
2.1	Үүнээс:Удирдлагын зардал	м.төг	1,057,189.7	1,410,646.9	1,647,922.0	237,275.1	116.8
3	**Ашиг(алдагдал)**	**м.төг**	**(11,034,165.6)**	**(14,960,039.7)**	**(14,269,659.7)**	**690,380.0**	**95.4**
4	Төсвийн төлбөрт:	м.төг	15,199,753.3	16,790,298.0	17,150,731.5	360,433.6	102.1
4.1	Орлогын татварт	м.төг	1,353.1	-	2,218.5	2,218.5	-
4.2	НӨАТ	м.төг	9,628,630.2	10,561,456.6	11,117,038.0	555,581.4	105.3
4.3	Бусад татвар, хураамж	м.төг	5,481,894.5	6,228,841.3	6,031,475.0	(197,366.3)	96.8
5	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төг	1.1	1.1	1.1	-	99.8
6	1 тн нүүрсний өртөг	төг	43,651.8	48,217.6	48,047.8	(169.8)	99.6
7	1 тн нүүрсний дундаж үнэ	төг	38,864.7	39,261.9	42,373.2	3,111.3	107.9
8	Хөрс хуулалтын коэффициент	м³/тн	4.1	4.2	4.2	0.1	101.4
9	Нийт авлага	м.төг	6,874,942.2	6,763,903.1	12,118,328.8	5,354,425.7	179.2
10	Нийт өглөг	м.төг	168,751,237.7	160,838,070.0	203,536,320.8	42,698,250.8	126.5
10.1	Үүнээс богино хугацаат өглөг	м.төг	77,401,172.3	68,821,450.0	115,919,774.4	47,098,324.4	168.4
В	**Бусад үзүүлэлт**						
1	Хөрөнгө оруулалт	м.төг	13,290,660.7	37,658,257.3	27,346,556.8	(10,311,700.5)	72.6
2	Нөхөн сэргээлтийн зардал	м.төг	45,156.0	519,621.4	257,598.8	(262,022.6)	49.6
3	Сарын дундаж цалин	м.төг	3,365.1	3,394.2	3,970.9	576.7	117.0
4	Нийт цалингийн сан	м.төг	17,590,214.5	19,835,582.5	20,434,016.9	598,434.4	103.0
5	Ажилчдын тоо	хүн	436	487.0	429	(58.2)	88.1

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани, түүний үйл ажиллагаа

Шивээ Овоо ХК нь эрхэм зорилго, үнэт зүйлээ "Байгаль орчинд ээлтэй, аюулгүй үйлдвэрлэл, өндөр бүтээмж бүхий уул уурхайн салбарын жишиг компани болно", "Мэргэжлийн өндөр ур чадвар, тэргүүний техник технологи бүхий уулын үйлдвэрлэл, хэрэглэгчдийн шаардлагад бүрэн нийцсэн чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ" гэж тодорхойлж, эрчим хүчний нүүрсний олборлолт, борлуулалтаараа Монгол улсын тэргүүлэгч компани болох алсын хараатай ажиллаж байна.

Шивээ овоо ХК нь Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын нутаг дэвсгэрт эрчим хүчний нүүрс олборлох тусгай зөвшөөрөлтэй, гол худалдан авагчид нь Дулааны 4 дүгээр цахилгаан станц, Амгалан дулааны станц ба мөн орон нутгийн хэрэглэгчдэд нүүрсээ борлуулж байна.

Шивээ овоо ХК нь нийт 13,419,101 ширхэг хувьцаатай ба хувьцааны 90 хувийг төрийн өмчит Эрдэнэс Монгол ХХК, 10 хувийг бусад хувьцаа эзэмшигчид эзэмшдэг, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээний компани юм.

Шивээ Овоо ХК нь дараах үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй байна.
Үүнд:

- Ашигт малтмал олборлох, боловсруулах үйлдвэрлэл,
- Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа,
- Компани нь тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг эрх бүхий байгууллагын олгосон зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх,
- Компани нь хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагаа.

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Шивээ Овоо ХК нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Компанийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Ирээдүйн өв сангийн тухай хууль, Газрын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон Монгол Улсын Их хурал, Засгийн газрын холбогдох тогтоол, шийдвэр, компанийн удирдлагаас баталсан дүрэм, журмуудыг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд *орсон* байна.
Үүнд:

- Ашигт малтмалын тухай хууль /шинэчилсэн найруулга
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;
- Нийгмийн даатгалын ерөнхий хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Зөрчлийн тухай хууль
- Компанийн тухай хууль.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үнэллээ.

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Тус компанийн бүтцэд дотоод хяналт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий 1 орон тоотой бөгөөд тайлант онд хууль, журам, тушаал шийдвэрийн хэрэгжилт, үйл ажиллагааны гүйцэтгэлийн хяналт, цаг ашиглалтын зэрэг 28 хяналтын ажил төлөвлөж гүйцэтгэж, гүйцэтгэх удирдлагад танилцуулан холбогдох зөвлөмжүүдийг өгч ажилласан байна.

Эрдэнэс Монгол ХХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудитын албанаас 2024 онд Шивээ овоо ХК-ийн 2023 он, 2024 оны 3 дугаар улирлын Худалдан авах ажиллагаа, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд шалгалт хийж урьдчилсан тайлан хүргүүлсэн байна.

Шалгалтын дүнгээр худалдан авах ажиллагааны менежментийн тогтолцоо, хүний нөөцийн чадавхи, хуулийн хэрэгжилт, хариуцлагыг сайжруулах 66 зөвлөмж өгсөн байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн үнэн зөв шалгуурт нийцсэн байдал 75 хувь, иж бүрэн шалгуурт нийцсэн байдал 64.3 хувь гэж урьдчилсан тайланд дурдсан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шивээ Овоо ХК-ийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг акруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус компани Эрдэнэс Монгол ХХК-ийн ТУЗ-ийн 2017 оны 45 дугаар тогтоолоор баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байсан. ТУЗ-ийн 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 76 дугаар тогтоолоор Эрдэнэс Монгол нэгдлийн хэмжээнд мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг баталж, 2025 оноос эхэлж мөрдөхөөр заасан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Шивээ Овоо ХК-ийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 22,427.8 сая төгрөгөөр буюу 24.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгөн хөрөнгө	2,723,457.2	3,132,061.1	408,604.0
Авлага	4,036,095.7	11,284,111.9	7,248,016.2
Бараа материал	25,112,107.4	23,802,832.6	(1,309,274.8)
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	398,196.9	411,737.0	13,540.2

Эргэлтийн хөрөнгийн дүн	**32,269,857.1**	**38,630,742.7**	**6,360,885.6**
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	59,426,400.8	75,499,432.3	16,073,031.5
Биет бус хөрөнгө	155,223.2	149,109.2	(6,114.0)
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө			-
Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө	627,169.4	627,169.4	-
Бусад эргэлтийн бус хөрөнгө			-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	**60,208,793.4**	**76,275,710.8**	16,066,917.4
Нийт хөрөнгийн дүн	**92,478,650.5**	**114,906,453.6**	**22,427,803.0**
Өр төлбөр			-
Богино хугацаат өр төлбөр	77,401,172.3	115,919,774.4	38,518,602.1
Урт хугацаат өр төлбөр	91,350,065.4	87,616,546.4	(3,733,519.0)
Өр төлбөрийн нийт дүн	**168,751,237.7**	**203,536,320.8**	**34,785,083.1**
Эздийн өмч: төрийн	1,207,710.0	1,207,710.0	-
хувийн	134,190.0	134,190.0	-
Хуримтлагдсан ашиг алдагдал	(77,614,487.1)	(89,971,767.2)	(12,357,280.1)
Эздийн өмчийн дүн	**(76,272,587.1)**	**(88,629,867.2)**	**(12,357,280.1)**
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	**92,478,650.5**	**114,906,453.6**	**22,427,803.0**

Мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, урьдчилж төлсөн зардал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн дансдад материаллаг хэмжээний өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгө 3,132.1 сая төгрөгт хүрч өмнөх оноос 408.6 сая төгрөгөөр өссөн нь Бор өндөрийн уулын баяжуулах үйлдвэрээс 739.2 сая төгрөгийн урьдчилгаа төлбөр орж ирсэн, оны эцэст Дулааны 4 дүгээр цахилгаан станцаас 2,400.0 сая төгрөгийн төлбөр төлөгдсөнтэй холбоотой байна.

Авлагын дансны үлдэгдэл 11,284.1 сая төгрөгт хүрч өмнөх оноос 7,248.0 сая төгрөгөөр өссөн нь нүүрсний үнэ нэмэгдсэн болон үндсэн худалдан авагчид болох Амгалан дулааны станцаас авах авлага 1,740.9 сая төгрөгөөр, Замын-Үүд дулааны станцаас авах авлага 279.3 сая төгрөгөөр, Чандмань илч Дорноговь ХХК-иас авах авлага 1,255.1 сая төгрөгөөр, Энержиплас ХХК-иас /Булган аймгийн дулааны станц/ авах авлага 489.8 сая төгрөгөөр, Улаанбаатар төмөр зам хувь нийлүүлсэн нийгэмлэгээс авах авлага 830.9 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой. Мөн өмнөх онуудад төлөгдсөн авлагад хамаарах 2,004.6 сая төгрөгийн найдваргүй авлагыг буцаах тохиргоо бичилтээр нэмэгдсэн байна. Бусад авлага нэмэгдсэн нь хөрөнгө оруулалттай холбоотойгоор нэмэгдсэн өртгийн албан татварын тохируулга бичилтээр 1,106.2 сая төгрөгийн авлага нэмэгдсэнтэй холбоотой байна.

Дансны авлагын 32.7 хувийг Амгалан дулааны станц ТӨҮГ-аас, 20.0 хувийг Чандмань илч Дорноговь ХХК-аас, 12.1 хувийг Энержиплас ХХК-аас, 11.4 хувийг Улаанбаатар төмөр зам хувь нийлүүлсэн нийгэмлэгээс, 8.0 хувийг Замын үүдийн дулааны станцаас, 2.8 хувийг Дулааны 4 дүгээр цахилгаан станцаас, 13.0 хувийг бусад харилцагчдаас авах авлага эзэлж байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 1,309.3 сая төгрөгөөр буурсан нь дизелийн түлш, тэсэлгээний материалыг Оросын холбооны улсаас оруулж ирдэг учир нийлүүлэлт саатаж нөөц багассан, мөн хангамжийн материалын үлдэгдэл буурснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 16,073.1 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу худалдаж авсан 27,346.6 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, Шивээ Овоо ХК-ийн бүх гишүүдийн хурлын 2018 оны 4 дүгээр тогтоолоор хувьчлагдсан орон сууцны үнэ 8.6 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хассан, 11,273.5 сая төгрөгийн элэгдлийн зардал тооцсонтой холбоотой байна.

01 ТОРИЙН АУДИТЫН ЕРӨНХӨЛӨГЧ ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 38,518.6 сая төгрөгөөр өссөн нь бэлтгэн нийлүүлэгч байгууллагад өгөх өглөг 13,242.6 сая төгрөгөөр, татварын өр 4,122.5 сая төгрөгөөр, богино хугацаат зээлийн өглөг 20,810.0 сая төгрөгөөр, тус тус нэмэгдсэнээс голлон шалтгаалжээ.

Татварын өр нэмэгдэхэд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн өглөг 2,597.4 сая төгрөгөөр, нэмэгдсэн өртгийн албан татварын өглөг 1,380.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлсөн байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг 1,735.7 сая төгрөгөөр буурч 5,564.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй болсон байна.

Урт хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 3,733.5 сая төгрөгөөр буурсан нь засгийн газрын дамжуулсан гадаад валютаарх зээлийн 818.9 сая төгрөгийн ханшийн бууралт болон 92.6 сая төгрөгийн хүүгийн өглөгийн өсөлт, урт хугацаат санхүүгийн түрээсийн өглөгт 3,110.0 сая төгрөг төлсөн, ажилчдын тэтгэврийн сангийн өглөгийн 102.8 сая төгрөгийн өсөлтөөс шалтгаалжээ.

Эздийн өмч дансны үлдэгдэл 12,357.3 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн алдагдал 14,269.7 сая төгрөг, өмнөх үеүдэд төлөгдсөн авлагад хамаарах найдваргүй авлагын хасагдуулгын залруулга 2,004.6 сая төгрөгөөр нэмэгдэж, 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар ажиллагсдад өгсөн шагнал урамшуулалд тавьсан актын төлбөр 92.2 сая төгрөгийг хуримтлагдсан ашиг/алдагдал дансанд бүртгэж хаасан нь нөлөөлсөн байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Шивээ Овоо ХК-ийн үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Шивээ Овоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд 2024 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 17 дугаар тогтоолоор, бизнес төлөвлөгөөнд 2024 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн 27 дугаар тогтоолоор тус тус тодотгол хийж, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 37,658.2 сая төгрөгөөр баталсан байна.

Бизнес төлөвлөгөөгөөр тайлант оны нийт орлогыг 115,709.5 сая төгрөгөөр, нийт зардлыг 130,669.6 сая төгрөгөөр, 14,960.0 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар баталсан байна.

Энэ нь өмнөх оны төлөвлөгөөнөөс нийт орлого 17,482.8 сая төгрөгөөр, нийт зардал 5,581.0 сая төгрөгөөр өсч, алдагдал 11,901.8 сая төгрөгөөр буурсан үзүүлэлт юм.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

Шивээ овоо ХК нь 2024 онд тодотгосон төлөвлөгөөгөөр 2,710.0 мянган тонн нүүрс олборлон, 2,690.0 мянган тонн нүүрс борлуулах зорилттой ажилласнаас нүүрс олборлолт 2,633.3 мянган тонн, борлуулалт 2,623.5 мянган тонн болж, нүүрс олборлолтын төлөвлөгөө 97.2 хувь, нүүрс борлуулалтын төлөвлөгөө биетээр 97.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

Тайлант онд 112,254.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 126,524.2 сая төгрөгийн зардал гарган, 14,269.7 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт зардал гүйцэтгэлээр 126,524.2 сая төгрөг болж, төлөвлөснөөс 4,145.4 сая төгрөг буюу 3.2 хувиар дутуу зарцуулсан байна.

Тэсэлгээний зардлыг 3,601.0 сая төгрөгөөр, дизель түлш 1,803.1 сая төгрөгөөр, тос, тослох материалын зардлыг 1,484.5 сая төгрөгөөр, цахилгаан эрчим хүчний зардлыг 705.0 сая төгрөгөөр, сэлбэг хэрэгслийн зардлыг 667.0 сая төгрөгөөр, хөрс тээврийн зардлыг 1,488.9 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

Төлөвлөснөөс дараах зардлууд хэтэрсэн байна. Үүнд:

1. Вагон ашиглалтын зардал: Төлөвлөгөөтэй харьцуулахад 6.8 хувь буюу 35.8 сая төгрөгөөр хэтэрсэн шалтгаан нь борлуулалтын орлого өсснөөр вагон ашиглалт, таталт тавилт, бичиг баримтын зардал нэмэгдсэнтэй холбоотой байна.

2. Дугуйн зардал: 12.9 хувь буюу 104.3 сая төгрөгөөр хэтэрсэн шалтгаан нь тоо ширхэгээр 147 ширхэг дугуй худалдан авахаар төлөвлөснөөс 139 ширхэгийг худалдан авч тоо ширхэгийн хувьд хэмнэсэн боловч 1 ширхэг дугуйг 5.5 сая төгрөгөөр худалдан авахаар төлөвлөсөн ч гүйцэтгэлээр зах зээлийн үнэ 6.6 сая төгрөг болсонтой холбоотой.

3. Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал: 35.8 хувь буюу 2,796.7 сая төгрөгөөр хэтэрсэн шалтгаан нь хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт орж технологийн техникүүд нэмж худалдан авсантай холбоотой.

4. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөвлөгөөтэй харьцуулахад 5.3 хувь буюу 138.9 сая төгрөгөөр хэтэрсэн шалтгаан нь нүүрсний олборлолт нэмэгдсэнтэй холбоотой.

5. Санхүүгийн зардал: Төлөвлөгөөтэй харьцуулахад 178.5 хувь буюу 2,179.8 сая төгрөгөөр хэтэрсэн нь хөрөнгө оруулалттай холбоотойгоор төлөвлөгөөгүй богино хугацаат зээл авсантай холбоотой.

6. Борлуулалт маркетингийн зардал: Төлөвлөгөөтэй харьцуулахад 2,003.9 сая төгрөгөөр хэтэрсэн нь Эрдэнэс Монгол компанид төлөх менежментийн төлбөрийг төлөвлөөгүйтэй холбоотой.

7. Цалингийн зардал: Төлөвлөгөөтэй харьцуулахад 3.0 хувь буюу 598.4 сая төгрөгөөр хэтэрсэн нь ТУЗ-ийн шийдвэрээр өвөлжилтийн бэлтгэл ажилтай холбоотойгоор 310.0 мянган тонн нүүрсний захиалга нэмэгдсэнээр төлөвлөгөөнд тодотгол оруулж ажил нэмэгдсэн боловч цалингийн санг өсгөөгүйтэй холбоотой байна.

Бизнес төлөвлөгөөгөөр 1 төгрөгийн борлуулалтанд 1.13 төгрөгийн зардал гаргахаар төлөвлөсөн ба гүйцэтгэлээр энэхүү зорилтот түвшингээ хангаж ажилласан байна.

Тайлант онд цэвэр алдагдал 14,269.6 сая төгрөг болж, төлөвлөснөөс 690.4 сая төгрөгөөр буюу 4.6 хувиар бага байгаа нь тэсэлгээний зардал, дизель түлш болон тос, тослох материалын зардлуудыг 26.4 хүртэл хувиар хэмнэсэн нь голлон нөлөөлжээ.

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Шивээ Овоо ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд Шивээ Овоо ХК, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн компанийн дотоод хяналтын тогтолцоог сайжруулах, шилэн дансны хуулийн хэрэгжилт, үндсэн хөрөнгийн үнэлгээтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Юнистар аудит ХХК-ийн ахлах аудитор Б.Тэрбиш, аудитор Б.Энхбаясгалан, Ч.Батмөнгөн, аудиторын туслах М.Цэцэгсүрэн, Ж.Нямцэцэг нар гүйцэтгэж, чанарын хяналтын менежер Р.Отгонжаргал, захирал М.Энхжаргал нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүү, нийцлийн аудитын газрын аудитор М.Лхагвасүрэн, аудитын менежер С.Нацагдорж, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Шивээ Овоо ХК 2024 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2025 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 3/107 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 108,217.2 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 1,082.2 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор орон тоог хэтрүүлэхгүй байх, хууль тогтоомжид зааснаас өөр шагнал урамшуулал олгохгүй, бичиг хэрэг хөтлөлтийг дотоод сүлжээ, цахим хэлбэрт шилжүүлэх зэргээр бичгийн цаас, хувилагч, хувилагчийн хорны болон тээврийн хэрэгслийн ашиглалт, шатахууны зардлыг хэмнэх, байгууллагын цахилгаан, дулаан, цэвэр усыг тоолууржуулах, цахилгаан хэрэгслийг техникийн тодорхойлолтын дагуу ашиглах зэрэг арга хэмжээ авч ажилласан байна. Ингэснээр нүүрс олборлолт өмнөх оноос 154.2 мянган тонноор буюу 6.2 хувиар өссөн боловч төлөвлөсөн 1 тонн нүүрсний өртөг 48,217.57 төгрөгөөс 48,047.79 төгрөг болж 0.4 хувиар буурсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн 3 зөрчлөөс албан тушаалтанд хариуцлага тооцох 1 албан шаардлага, асуудлыг сайжруулж шийдвэрлэх 2 зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 25 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нөхцөл байдал:

Шилэн дансны цахим хуудсанд 159 мэдээлэл байршуулахаас 152 мэдээллийг хугацаанд нь оруулж 1 мэдээллийг хугацаа хоцроосон, 4 мэдээлэл хугацаа болоогүй, 2 мэдээллийг цахим хуудсанд байршуулаагүй байна. Шилэн дансны мэдээлсэн байдал 96.7 хувь, хугацаандаа оруулсан 98.9 хувь байна.

Илрүүлэлт. Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд 18,946.6 сая хөрөнгийн зардлын төлөвлөгөө болон гүйцэтгэл, компанийн бүтээгдэхүүний үнийн өөрчлөлтийн мэдээлэл зэрэг 2 мэдээллийг байршуулаагүй, 1 мэдээллийг хугацаа хоцроосон байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1. "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 6 дугаар зүйлийн 6.1 "энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ": 6.2.4."хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, төр, хувийн хэвшлийн түншлэлийн жагсаалт"; 6.4.2 "тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хуулиар тогтоосон хугацаанд, иж бүрэн, үнэн зөв байршуулж байх зөвлөмж өгсөн.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Худалдан авах ажиллагаа

Шивээ Овоо ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор батлагдсан 2024 оны бизнес төлөвлөгөөнд үндэслэн Гүйцэтгэх захирлын 2024 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн А/01 дүгээр тушаалаар 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталсан.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 2024 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн А/83 дугаар тушаалаар тодотгол хийж, нийт 86,972.4 сая төгрөгийн 335 нэр төрлийн бараа, ажил үйлчилгээ худалдан авахаар төлөвлөсөн байна.

Мөн Шивээ овоо ХК-ийн ТУЗ-ийн 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 17 дугаар тогтоолоор хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталж, 2024 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн 27 дугаар тогтоолоор тодотгол хийж, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг нийт 37,658.2 сая төгрөгөөр баталсан байна.

Нийт 124,630.6 сая төгрөгийн худалдан авалт төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 113,274.5 сая төгрөгийн худалдан авалт хийсэн байна. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу гүйцэтгэсэн эсэхэд аудитын төлөвлөгөөний дагуу хяналтын горим сорил хэрэгжүүллээ.

01 ТӨРИЙН АУДИТЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Илрүүлэлт:Худалдан авах ажиллагаанд хэрэгжүүлсэн аудитын горим сорилын үр дүнд 4,365.2 сая төгрөгийн үнийн дүн бүхий 11 гэрээ хийхдээ цахим системд нээлттэй зарлаагүй. Мөн, төлөвлөгөөнд тодотгол оруулалгүйгээр 3,518.2 сая төгрөгийн худалдан авалт хийсэн. Өмнөх аудитаар хүргүүлсэн аудитын шийдвэрийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2 "Гэрээ шууд байгуулах тухай зарлалыг бараа, ажил, үйлчилгээний ерөнхий мэдээллийн хамт цахим системд нийтэлж, энэ хуулийн 54.8-д зааснаар аж ахуй эрхлэгчид хэлэлцээ хийх урилга хүргүүлнэ", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4 "хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох" гэж заасантай тус тус нийцээгүй, Төрийн аудитын тухай хуулийн 42.1 "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно." гэж заасан үндэслэл бүрдсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагаа хуульд нийцээгүй, өмнөх аудитаар албан шаардлага өгсөн зөрчлийг давтан гаргасан тул буруутай албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэв.

Бусад хуулийн нийцэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Гүйцэтгэх захирлын 2024 оны А/05, А/116 дугаар тушаалаар баталсан Компанийн удирдлага, зохион байгуулалтын бүтэц нь Компанийн тухай хуульд заасан эрх бүхий албан тушаалтны статус болон компанийн дотоод хяналтын тогтолцоо үр нөлөөтэй байх нөхцлийг хангахгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно", Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1 "Компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга зэрэг компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно" гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг компанийн дотоод хяналт хэрэгжихүйц байдлаар зохион байгуулах зөвлөмж өгсөн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансны болон худалдан авах ажиллагаа нь холбогдох хууль тогтоомжид нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2024 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, цалингийн зардал, авлага, урьдчилж төлсөн зардал тооцоо дансдад горим сорил хэрэгжүүлж авлага, урьдчилж

төлсөн зардал тооцоо, үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудлуудыг илрүүлэн танилцуулж, үр дүнг нэгтгэн жилийн эцсийн аудитын тайланд тусгалаа.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар санхүүгийн аудиттай холбоотой 3, санхүүгийн аудитын хүрээнд шалгасан нийцлийн аудитаар 1, нийт 4 зөрчил илрүүлж, 2.2 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 365.4 сая төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлсэн. Төлбөрийн акт болон 177,560.7 сая төгрөгийн 2 албан шаардлагыг бүрэн биелүүлж, худалдан авах ажиллагаанд өгсөн 1 албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан байна. Худалдан авах ажиллагаанд давтан гаргасан зөрчилд буруутай албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага өгсөн.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	2,249.5	1	2,249.5	100.0
Албан шаардлага	3	365,360.8	2	177,560.7	66.33
Нийт дүн	**4**	**367,610.3**	**3**	**179,810.2**	**75.0**

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татсан асуудал байхгүй байна.

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТ ҮҮ САНАЛ ДҮГНЭЛТ

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,004.6 сая төгрөгийн алдаа[1] илэрснийг санхүүгийн тайланд залруулаа.

Залруулсан алдаа:

- Өмнөх онуудад төлөгдсөн авлагад хамаарах 2,004.6 сая төгрөгийн найдваргүй авлагын буцаах тохиргоо бичилт хийгээгүйг хуримтлагдсан ашиг алдагдал дансанд хааж залруулав.

Аудитаар нийт 894.8 сая төгрөгийн 5 зөрчил[2] илэрснээс, 2.4 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 892.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага өгч, үндсэн хөрөнгөтэй холбоотой 1 зөвлөмж хүргүүлэв.

Аудитаар нийт 894.8 сая төгрөгийн санхүүгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 1,082.2 сая төгрөгөөс бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Компанийн ажилтан бус, үйлдвэрчний эвлэлийн хорооны ажилтанд 2.4 сая төгрөгийн үр дүнгийн шагналт цалин олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1."Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3 "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь</u>: Компанийн ажилтан бус хүнд олгосон шагналт цалинг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоосон.

5.2 Албан шаардлага

1. Тайлант оны эцэст 11,284.1 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байгаагаас 102.5 сая төгрөгийн авлагыг харилцагчтай тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь</u>: Авлагын үлдэгдлийг харилцагчтай тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчлийг арилгах, цаашид хууль тогтоомж хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

2. Урьдчилж төлсөн зардал, тооцоо дансны үлдэгдэл 411.7 сая төгрөг байгаагаас олон жилийн насжилттай 326.2 сая төгрөгийн үлдэгдэл тооцоо байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусгах илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Шийдвэрлээгүй олон жил болсон урьдчилж төлсөн зардал тооцооны үлдэгдлийг харилцагчтай тооцоо нийлж баталгаажуулж, шийдвэрлээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

3.Бараа материалын дансанд бүртгэлтэй, техникийн шинэчлэлтэй холбоотойгоор компанид ашиглагдахгүй болсон 193 нэрийн 463.7 сая төгрөгийн сэлбэг агуулахад хадгалагдаж байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйл. 2/ "үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах" Шивээ овоо ХК-ийн гүйцэтгэх захирлын 2017 оны А/79 дүгээр тушаалаар баталсан "Сэлбэг хэрэгсэл, бараа материалын захиалга гаргах, бэлтгэн нийлүүлэх, нөөц бүрдүүлэх, орлогод авах, зарлага гаргах журам"-ын 4.5 "Хагас бүтэн жилийн тооллогын дүнгээр компанийн зохистой нөөцийн бүрдүүлэлтийн байдалд дүн шинжилгээ хийж... илүүдэлтэй эргэлт удаан байгаа хэсгийг худалдан борлуулж, эргэлтийн хөрөнгийн үлдэгдлийг бууруулах" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материалын дансанд бүртгэлтэй, ашиглагдахгүй болсон сэлбэгийг эргэлтэд оруулах, ашиглах зэргээр хөрөнгийн үр ашгийг сайжруулах, бараа материалыг үр ашиггүй удаан хадгалж байгаа зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй, ашиглагдаж байгаа 51,384.8 сая төгрөгийн дансны үнэтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 2,085 ширхэг хөрөнгийг дахин үнэлүүлэн бодит үнэ цэнээр бүртгэх асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх саналыг хүргүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3. "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.1 "элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны өртгөө нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн тогтоох" гэж заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийн асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх.

Зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 9 дүгээр сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

01 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Өмнөх онуудад төлөгдсөн 2,004.6 сая төгрөгийн найдваргүй авлагыг буцаах тохируулах бичилт хийгээгүй байна.	1	2,004,629.6	-	-	1	2,004,629.6	1	2,004,629.6	-	-	-	-
	Дүн	**1**	**2,004,629.6**	**-**	**-**	**1**	**2,004,629.6**	**1**	**2,004,629.6**	**-**	**-**	**-**	**-**

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн
1	Компанийн ажилтан бус, үйлдвэрчний эвлэлийн хорооны ажилтанд үр дүнгийн шагналт цалин олгосон.	1	2,357.2	1	2,357.2	-	-	-	-
2	Тайлант оны эцэст 11,284.1 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байгаагаас 102.4 сая төгрөгийн авлагыг харилцагчтай тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	1	102,481.5	-	-	1	102,481.5	-	-
3	Тайлант оны эцэст урьдчилж төлсөн зардал, тооцоо дансны үлдэгдэл 411.7 сая төгрөг байгаагаас олон жилийн насжилттай 326.2 сая төгрөгийн үлдэгдэл тооцоо байна.	1	326,239.5	-	-	1	326,239.5	-	-
4	Бараа материалын дансанд бүртгэлтэй, техникийн шинэчлэлтэй холбоотойгоор компанид ашиглагдахгүй болсон 193 нэрийн 463.7 сая төгрөгийн сэлбэг агуулахад хадгалагдаж байна.	1	463,769.2	-	-	1	463,769.2	-	-
5	Үндсэн хөрөнгийн дансанд, үйл ажиллагаанд хэвийн ашиглагдаж байгаа 51,384.8 сая төгрөгийн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, дансны үлдэх өртөггүй 2,085 ширхэг хөрөнгийг цаашид ашиглах болон дахин үнэлүүлэн бодит үнэ цэнээр бүртгэх асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх саналыг хүргүүлээгүй байна	1	-	-	-	-	-	1	-
	Дүн	**5**	**894,847.4**	**1**	**2,357.2**	**3**	**892,490.2**	**1**	**-**

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд 18,946.6 сая хөрөнгийн зардлын төлөвлөгөө болон гүйцэтгэл, компанийн бүтээгдэхүүний үнийн өөрчлөлтийн мэдээлэл зэрэг 2 мэдээллийг байршуулаагүй байна.	1	18,946.6	-	-	1	18,946.6
Дүн	**1**	**18,946.6**	**-**	**-**	**1**	**18,946.6**
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Худалдан авах ажиллагаанд хэрэгжүүлсэн аудитын горим сорилын үр дүнд 4,365.2 сая төгрөгийн үнийн дүн бүхий 11 гэрээ хийхдээ цахим системд нээлттэй зарлаагүй. Мөн төлөвлөгөөнд тодотгол оруулалгүйгээр 3,518.2 сая төгрөгийн худалдан авалт хийсэн байна.	1	7,883,487.2	1	7,883,487.2	-	-
Гүйцэтгэх захирлын 2024 оны А/05, А/116 дугаар тушаалаар баталсан Компанийн удирдлага, зохион байгуулалтын бүтэц нь Компанийн тухай хуульд заасан эрх бүхий албан тушаалтны статус болон компанийн дотоод хяналтын тогтолцоо үр нөлөөтэй байх нөхцлийг хангахгүй байна.	1	-	-	-	1	-
Дүн	**2**	**7,883,487.2**	**1**	**7,883,487.2**	**1**	**-**
Нийт дүн	**3**	**7,902,433.8**	**1**	**7,883,487.2**	**2**	**18,946.6**

Утас: +976 51 261585
Факс: +976 11 323266, 324653

Цахим шуудан: info@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

Хаяг: Засгийн газрын IV байр
Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг
Улаанбаатар-15160, Монгол Улс